



“ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ” ХК

Тендер шалгаруулалт
гэрээний нэр:

**УСАЛГААНЫ СИСТЕМ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ
СОНГОН ШАЛГАРУУЛАХ ХАРЬЦУУЛАЛТЫН
ТЕНДЕР**

Тендер шалгаруулалт
гэрээний дугаар:

ЭТТ/202001127

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

“Эрдэнэс-Тавантолгой” ХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Усалгааны систем**–ийг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 10 цаг 00** минутаас өмнө Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 10 цаг 30** минутад нээнэ.

Дотоодны давуу эрх тооцох эсэх: **Үгүй**

Сонирхсон этгээд тендертэй холбоотой бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджав-8,
Финанс төв, 5 давхар 503 тоот
Утас: +976-7505-5555-511

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.









Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн 1 жилийн буюу 2019 оны аудитлагдсан санхүүгийн тайлан. 2. 2018, 2019 оны аль нэг жилд ижил төстэй усалгааны систем нийлүүлж байсан туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн 1-ээс доошгүй ажлын гэрээний хуулбарыг нотариатаар гэрчлүүлэх, гэрээ дүгнэсэн акт эсхүл бараа хүлээлцсэн акт ирүүлэх/. 3. Компанийн танилцуулга. 4. Компанийн гэрчилгээний хуулбар. 5. Татварын тодорхойлолт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-д тендер нээх өдрийн байдлаар татан авахад өр төлбөргүй болон дутуу төлөлтгүй байх. 6. Шүүхийн төрөлжсөн архивын газраас иргэний хэргийн шүүхийн тодорхойлолт ирүүлэх. /тендер зарласан өдрөөс хойших байдлаар/ 7. ШШГЕГ-ын тодорхойлолт. /тендер зарласан өдрөөс хойших байдлаар/ 8. Тендерт шалгарсан тохиолдолд техникийн тодорхойлолтын шаардлага хангаагүй бараа нийлүүлбэл захиалагчийн саналаар гэрээг цуцлахад татгалзах зүйлгүй талаарх албан бичиг ирүүлэх. 9. Тендерт шалгарсан тохиолдолд тендерт санал болгосон хугацаандаа бараа нийлүүлээгүй бол захиалагчийн саналаар гэрээг цуцлахад татгалзах зүйлгүй талаарх албан бичиг ирүүлэх. 10. Техникийн тодорхойлолтод заасан үзүүлэлтийг хангасан бараа бүтээгдэхүүн эсэхийг нотлох баримт ирүүлэх. /Үйлдвэрлэгчээс ирүүлсэн барааны үзүүлэлт/ 11. Нийлүүлэх бараа бүтээгдэхүүнүүдэд баталгаат хугацаа ирүүлнэ. Баталгаат хугацаа нь 1 жил байх бөгөөд баталгаат хугацааны үед ашиглалтын бус эвдрэл гарсан тохиолдолд засвар үйлчилгээ үзүүлэх эсвэл шинээр сольж өгөхийг зөвшөөрсөн албан бичиг ирүүлэх. <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай эсэх: - Шаардлагагүй</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Хаяг: Цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр /pdf/-ээр илгээнэ.</p> <p>Огноо: 2020 оны 08 дугаар сарын 17-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 00 минут.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджав-8, Финанс төв, Утас: +976-7505-5555-511</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 5 давхар 503 тоот</p> <p>Огноо: 2020 оны оны 08 дугаар сарын 17-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 30 минутад нээнэ.</p>
ТӨӨЗ 6.2	<ol style="list-style-type: none"> 1. Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцгүй

Гурав. **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

№	Бараа ажил үйлчилгээ	Тоо хэмжээ	Техникийн тодорхойлолт	Зураг	
1	Бороожуулагчийн хөл	1000ш	Газарт суурьлуулж бороожуулагч байрлуулах, 35 см-н өндөртэй, бат бөх, нугарч хугардаггүй байх		
2	Бороожуулагч толгой	1000ш	Эргэлт сайтай, бат бөх байх.		
3	Хоолой 63 мм	250м	PE хоолой, гадна диаметр 63 мм, 5 мм зузаан, 8.0 bar		
4	Хоолой 50 мм	250м	PE хоолой, гадна диаметр 63 мм, 5 мм зузаан, 8.0 bar		
5	Хоолой 16 мм	4000м	PE хоолой, гадна диаметр 16 мм, 1.2 мм зузаан, 4.0 bar		
6	Хоолой 12мм	2000м	LDPE хоолой, гадна диаметр 12 мм, 1.4 мм зузаан, 6.0 bar		
7	Салаалагч 63 мм	25ш	3-н тийш салаалагч 63, 50, 40мм-ийн салаалагч		
8	Салаалагч 50 мм	25ш			
9	Салаалагч 40 мм	25ш			
10	Салаалагч 16 мм	50ш	3-н тийш салаалагч 12, 16, 16x12мм-ийн салаалагч	 XFD TEE	
11	Салаалагч 12 мм	50ш			
12	Салаалагч 16x12	50ш			
13	Эмээл 63x16 мм	100ш	Хавчигч эмээл 63x16мм		
14	Эмээл 50x16 мм	100ш	Хавчигч эмээл 50x16мм		
15	Эмээл 40x16 мм	100ш	Хавчигч эмээл 40x16мм		
16	Хаалт 63 мм	50ш	63 мм-ийн хоолойнд холбох хаалт		
17	Хаалт 50 мм	50ш	50мм-ийн хоолойнд холбох хаалт		
18	Хаалт 40 мм	50ш	40мм-ийн хоолойнд холбох хаалт		
19	Хаалт 16 мм /түгжигч төмрийн хамт/	250ш	16мм-ийн хаалт /түгжигч/ төмөр хавчаарын хамт		

20	Шилжүүлэгч 63x50	50ш	63 мм-ийн хоолойноос 50 мм-н хоолойнд холбогч	
21	Шилжүүлэгч 50x40	50ш	50 мм-ийн хоолойноос 40 мм-н хоолойнд холбогч	
22	Шилжүүлэгч 16x16	100ш	16 мм-ийн хоолойноос 16 мм-н хоолойнд холбогч	
23	Шилжүүлэгч 16x12	100ш	16 мм-ийн хоолойноос 12 мм-н хоолойнд холбогч	
24	Шилжүүлэгч 12x12	100ш	12 мм-ийн хоолойноос 12 мм-н хоолойнд холбогч	
25	Шүүр 2"	20ш	Шүүлтүүр 2", 63 мм-н хоолойнд холбогдох, эр шурагтай	
26	Холбогч 2"x63 мм	20ш	2"-ээс 63 мм-н хоолойнд холбох зориулалттай, эм шурагтай	
27	Холбогч 63x63 мм	25ш	63мм-ийн хоолойг 63мм-ийн хоолойтой холбох	
28	Холбогч 63x50 мм	25ш	63мм-ийн хоолойг 50мм-ийн хоолойтой холбох	
29	Холбогч 50x50 мм	25ш	50мм-ийн хоолойг 50мм-ийн хоолойтой холбох	
30	Холбогч 50x40 мм	25ш	50мм-ийн хоолойг 40мм-ийн хоолойтой холбох	
31	Холбогч 40x40 мм	25ш	40мм-ийн хоолойг 40мм-ийн хоолойтой холбох	
32	Холбогч /эр шурагтай/	500ш	Хоолойг эмээлтэй холбох холбогч	
33	Төгсгөвч 63 мм	50ш	Хоолойнуудын төгсгөлд холбох	
34	Төгсгөвч 50 мм	50ш		
35	Төгсгөвч 40 мм	50ш		
36	Төгсгөвч 16 мм	100ш	Хоолойнуудын төгсгөлд холбох	
37	Төгсгөвч 12 мм	100ш		

38	Булан 63 мм	30ш	63, 50, 40 мм-ийн хоолойг усалгааны системд холбоход хэрэглэгдэнэ.	
39	Булан 50 мм	30ш		
40	Булан 40 мм	30ш		
41	Булан 16 мм	100ш	16, 12мм-ийн хоолойг усалгааны системд холбоход хэрэглэгдэнэ.	
42	Булан 12 мм	100ш		
43	Дуслуур 8 л/цаг	1000ш	Усалгааны системд холбох, усыг хэмнэлттэй зарцуулах дуслуур	
44	Шланк	500м	Урагддаггүй хөлддөггүй 25мм-ийн мод усалгааны шланк	
45	Усалгааны системийн гадас	500ш	Усалгааны системийг хөдөлж, салахаас хамгаална.	
46	Усны цахилгаан насос	3ш	Усалгааны системтэй холбох, усалгаа арчилгаа хийхэд, оролт гаралтын цоргоны хэмжээ 50мм, ~400 л/цаг	
47	Хуванцар таслагч хайч	3ш	Хуванцарыг шаардлагатай газраар хуваах, тасдах	
48	Цоолтуур	5ш	12 болон 16мм-ийн хоолойг цоолох	
49	Цоолтуур	5ш	40, 50, 60 мм-ийн хоолойг цоолох	
50	Батарей дрилл	1ш	Усалгааны системийн хоолойны эрэг боолтыг суллах, чангалах. Хайрцагтай, батарейгаа цэнэглэж хэрэглэдэг. Олон төрлийн боолт чангалах толгой болон дагалдах хэрэгсэлтэй байх	

1. **Барааны тодорхойлолт:** [Барааны тодорхойлолт, техникийн үзүүлэлтийг энд бичнэ.]
2. **Стандарт:** Захиалагч холбогдох стандартыг заана. Эсхүл [Тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.] гэж бичнэ
3. **Баглаа, боодол:** [Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолд тавих нөхцөлийг тодорхой заана. Баглаа боодлын нөхцөлийг цаг уур, давс, барааны жин, ачих буулгах хэрэгсэл, далайгаар тээвэрлэх тохиолдолд хөлөг онгоцны тавцан дээр, эсхүл доор тээвэрлэх зэргийг харгалзаж тодорхойлно. Ачааг хэрхэн тэмдэглэх болон хаяглах, ямар баримт бичиг дагалдахыг энд тодорхойлно.]
4. **Бараа хүргэх газар:** Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджав-8, Финанс төв, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн төв оффис
5. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Усалгааны систем	Техникийн тодорхойлолтод заасны дагуу	Техникийн тодорхойлолтод заасан тоо хэмжээгээр	Техникийн тодорхойлолтод заасны дагуу	“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн төв оффис	<i>Гэрээ байгуулагд санаас хойш 14 хоногийн дотор</i>	<i>Гэрээ байгуулагд санаас хойш 21 хоногийн дотор</i>	

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [моо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан моо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|--|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлд заасны дагуу барааг хүлээн авах үед Захиалагч талаас томилсон эрх бүхий этгээд барааг шалгаж хүлээн авна. Барааг шалгахтай холбоотой бүхий л зардлыг Гүйцэтгэгч тал хариуцна. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:

1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;

Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна. |
| 3. Төлбөр (ГЕН – 7) | 4.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
Гэрээнд заасан барааг 100 хувь нийлүүлсэн болохыг нотолсон барааг хүлээн авсан акт болон гэрээ дүгнэх актыг үндэслэн хуанлийн 60 хоногийн дотор нийлүүлэгч талд төлбөрийг бүрэн төлнө. |
| 4. Алданги оногдуулах (ГЕН - 9) ¹ | 6.1. Алданги ноогдуулах хэмжээ хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн [0.5%] байна

Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн [10 хувь] байна. |

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]